



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 84

Улаанбаатар хот

### Хөрөнгө, өр төлбөр бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дах заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээлээр санхүүжүүлсэн “Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн төсөл”-ийн хүрээнд бий болсон нийт 15,069,521,237.50 (арван таван тэрбум жаран есөн сая таван зуун хорин нэгэн мянга хоёр зуун гучин долоон төгрөг тавин мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгө, холбогдох өр төлбөрийг “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Тавинбэх, “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баярсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө, өр төлбөрийг Сангийн яамтай тооцоо нийлэн хүлээн авах, хүлээлцэх, тооцоо нийлэх ажлыг компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ  
132004624  
7-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар  
2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн  
..... дугаар тогтоолын хавсралт

"Улаанбаатар дулааны сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгө бүртгэх хөрөнгө (өр төлбөр)-ийн жагсаалт

Хөрөнгийн нэр	Хүчин чадлын нэгж	Тоо хэмжээ	Гэрээний дүн /гүйцэтгэлээр/	Капиталжуулах дүн			Хөрөнгө бүртгэх дүн (төгрөг)
				Зээлийн шимтгэл	Зээлийн хүү	Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж	
Тк-824 цэгээс Тк-844 цэг хүртэлх 2х400, 2х500 мм-ийн голчтой шугамыг 2х600 мм-ийн голчтой болгон шинэчлэн солих ажлын хүрээнд бий болсон хөрөнгө	Ф600мм	1007.5 хос.метр	3,777,142,537.00	35,741,489.37	188,321,180.57	24,931,569.66	4,026,136,776.60
Тк-824 цэгээс Тк-844 цэг хүртэлх 2х400, 2х500 мм-ийн голчтой шугамыг 2х600 мм-ийн голчтой болгон шинэчлэн солих ажлын хүрээнд бий болсон хөрөнгө	Ф600мм	840 хос.метр	3,581,301,007.00	35,570,897.09	182,798,730.72	25,176,673.66	3,824,847,308.47
Тк-802 цэгээс Тк-824 цэг хүртэлх 2х500 мм-ийн голчтой шугамыг 2х600 мм-ийн голчтой болгон шинэчлэн солих ажлын хүрээнд бий болсон хөрөнгө	Ф600мм	810 хос.метр	3,712,255,371.00	35,358,331.12	201,718,466.37	23,440,272.93	3,972,772,441.42
2ф600мм-ийн голчтой дулааны шугам шинээр татаж холбох / ХУД-ийн 15-р хороо, БЗД-ийн 26-р хороо /	Ф600мм	514 хос.метр	3,062,194,070.00	28,983,765.31	132,868,152.12	21,718,723.58	3,245,764,711.01
			<b>14,132,892,985.00</b>	<b>135,654,482.89</b>	<b>705,706,529.78</b>	<b>95,267,239.84</b>	<b>15,069,521,237.50</b>
<b>НИЙТ ДҮН</b>							(арван таван тэрбум жаран есөн сая таван зуун хорин нэгэн мянга хоёр зуун гучин долоон төгрөг тавин мөнгө)